



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар зарим зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын хэрэгжилт 86.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллахыг “Орхон АЗЗА” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал (Ц.Батзориг)-д үүрэг болгосугай.

2.“Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй:

2.1.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал болон тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах;

2.2.Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналтад тавьж ажиллах.

3.“Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Батзориг)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2.Элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнээ нөхсөн 60 нэр төрлийн 826,58 (найман зуун хорин зургаан сая тавин найман мянга) сая төгрөгийн балансын үнэ бүхий цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр журмын дагуу бэлтгэн Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.3.Үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.15-д заасны дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж, компанийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоод хяналтыг удирдан зохион байгуулж, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын асуудалд хяналт тавьж ажиллах.

132001102  
3-r huraldaan.docx

3.4.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

